



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/35

Шивээговь сум

Нийтийн их цэвэрлэгээ зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.л, 29.2, 31 дүгээр зүйлийн 31.1.7, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5, 9.4.12, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын төвийн нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх бүх нийтийн их цэвэрлэгээг 14 хоног тутмын Баасан гарагт суманд үйл ажиллагаа явуулж буй бүх албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, нийт иргэдийн дунд тогтмол зохион байгуулсугай.

2. Нийтийн их цэвэрлэгээний хуваарийг 1 дүгээр хавсралтаар, албан байгууллага, аж ахуйн нэгжийн Ногоон байгууламжийн хашааг засах, босгох, усалгаа, арчилгаа, цэвэрлэгээ хийх хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хуваарийн дагуу өөрийн байгууллагынхаа хуваарьт газруудад цэвэрлэгээ, усалгаа арчилгаа хийлгэх, багаж хэрэгслээр хангах, цэвэрлэгээний ажилд ажилтан, албан хаагчдаа бүрэн хамруулах, цэвэрлэгээг чанартай хийж гүйцэтгэн хогийн цэгт ачиж тээвэрлэн төвлөрүүлэхийг албан байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4. Сумын төвийн нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх бүх нийтийн их цэвэрлэгээг тогтоосон хугацаанд чанартай зохион байгуулж ажиллахыг 1, 2 дугаар багийн Засаг дарга нарт, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, Байгаль хамгаалагч нарт даалгасугай.

42121-39